



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 01 сарын 22 өдөр

Дугаар А/74

Есөнбулаг

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 11 дүгээр тогтоол, 2022 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 78 дугаар тогтоол, Засаг даргын Удирдлагын зөвлөлийн 2024 оны 3 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.3.1 дэх зорилтын хүрээнд аймгийн Ерөнхий боловсролын III, IV-р сургуулийн Тусгай хэрэгцээт боловсролын багш Н.Жаргалан, Р.Баярцацрал нарыг тус бүр 3,000,000 (гурван сая) төгрөгөөр урамшуулсугай.

2. Урамшуулалд шаардагдах 6,000,000 (зургаан сан) төгрөгийг Боловсролын чанарыг сайжруулах хөтөлбөрийн урамшуулал арга хэмжээний батлагдсан зардлаас гаргаж Боловсрол шинжлэх ухааны газар (Ж.Амгаланбаатар)-т шилжүүлэхийг Засаг даргын Тамгын газар (Ш.Эрдэнэбат)-т зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтийг хангаж, хөрөнгийн зарцуулалтыг тайлагнан ажиллахыг Боловсрол, шинжлэх ухааны газар (Ж.Амгаланбаатар)-т үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс (Э.Пүрэвжав), Нийгмийн бодлогын хэлтэс (С.Мөнхжаргал)-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

О.АМГАЛАНБААТАР



